

## Хог хаягдлын мэргэжлийн зөвлөлийн дүрэм

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хог хаягдлын талаархи хууль тогтоомжийг боловсронгуй болгох, менежментийг сайжруулах талаар санал зөвлөмж гаргах болон хог хаягдлын тухай хуулийн 8.1.4-т “аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгох” гэж заасны дагуу зөвшөөрөлтэй холбоотой дүгнэлт, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус байгууллага мөн.

1.2. Мэргэжлийн зөвлөл нь үйл ажиллагаандаа Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэхэд хяналт тавих тухай Базелийн конвенци /1996/, Аюултай зарим химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх, урьдчилан мэдээлж зөвшилцөх журмын тухай Роттердамын конвенци /2000/, Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенци /2003/, бусад хууль тогтоомж болон мөн энэхүү дүрмийг дагаж мөрдөнө.

1.3. Мэргэжлийн зөвлөл нь ажлаа байгаль орчин асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тайлагнана.

### Хоёр. Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, зохион байгуулалт

2.1. Мэргэжлийн зөвлөлийн дарга нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын дарга байна.

2.2. Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд холбогдох яам, агентлаг, эрдэм шинжилгээний байгууллагын зохих албан тушаалтан болон эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын төлөөлөл байна.

2.3. Мэргэжлийн зөвлөл 15-аас доошгүй гишүүнтэй байх ба гишүүд нь хог байгаль орчин, хаягдлын чиглэлээр 10-аас дээш жил ажилласан туршлагатай байна.

### Гурав. Мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам

3.1. Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь Зөвлөлийн хурал байна.

3.2. Мэргэжлийн зөвлөлийн хурлыг жилд 2-оос доошгүй удаа хийнэ. Ээлжит бус хурлыг зөвлөлийн дарга зарлан хуралдуулж болно.

3.3. Мэргэжлийн зөвлөлийн хурлаар асуудал хэлэлцүүлэх байгууллага холбогдох материалаа зөвлөлийн нарийн бичгийн даргад хурал болохоос 7 хоногийн өмнө хүргүүлнэ. Хурлын материалыг хурал болохоос 5 хоногийн өмнө гишүүдэд тараана.

3.4. Мэргэжлийн зөвлөлийн хурлыг гишүүдийн олонх ирсэн тохиолдолд хуралдуулна.

3.5. Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлыг гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэж, хог хаягдлын талаархи хууль тогтоомжийг боловсронгуй болгох, менежментийг сайжруулах санал, Хог хаягдлын тухай хуулийн “8.1.4.аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгох” гэж заасан зөвшөөрөлтэй холбоотой дүгнэлт, зөвлөмж гаргана. Зөвлөмжийг зөвлөлийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

3.6. Хурлын тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтлөж, мэргэжлийн зөвлөлийн дарга гарын үсэг зурна.

### **Дөрөв. Мэргэжлийн зөвлөлийн үүрэг, хариуцлага**

4.1. Мэргэжлийн зөвлөл нь дараах үүрэгтэй байна:

4.1.1. аюултай хог хаягдалтай холбогдсон бодлого тодорхойлох, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгоход санал гаргах;

4.1.2. хог хаягдлын талаархи хууль тогтоомжийг боловсронгуй болгох, менежментийг сайжруулах санал, зөвлөмж гаргах;

4.1.3. Хог хаягдлын тухай хуулийн 8.1.4-т “аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгох” заасан зөвшөөрөлтэй холбоотой дүгнэлт, зөвлөмж гаргах.

4.1.4. Аюултай хог хаягдалтай холбоотой, түүнийг дахин боловсруулах үйл ажиллагааг зохицуулах асуудлаар ажилд арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах.

4.1.5. Зөвлөлийн хуралд 3 удаа дараа оролцоогүй болон хурлын үйл ажиллагаанд илт ашиг сонирхолын үүднээс хандсан бол зөвлөлийн гишүүнээс түдэлзүүлж, холбогдох байгууллагын албан тушаалтныг дахин томилно.

## ТАНИЛЦУУЛГА

“Хог хаягдлын тухай ” хуулийн 12.1-д Аюултай болон энгийн хог хаягдлын бодлого, зохицуулалтын асуудлаар мэргэжлийн санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөлийг төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажлуулахаар заасны дагуу 2017 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн “Хог хаягдлын мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай” А/205 дугаар тушаалаар байгуулагдан ажиллаж байна.

Зөвлөлийн бүрэлдэхүүн нь 16 гишүүнтэй бөгөөд холбогдох яам, агентлаг, шинжлэх ухааны байгууллагуудын төлөөлөл багтаж байна. Зөвлөлийн үүрэг нь:

- Хог хаягдлын талаархи хууль тогтоомжийг боловсронгуй болгох, менежментийг сайжруулах санал, зөвлөмж гаргах;
- Хог хаягдлын тухай хуулийн 8.1.4-т “аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгох” гэж заасны дагуу зөвшөөрөлтэй холбоотой дүгнэлт, зөвлөмж гаргах.

Иймд аюултай хог хаягдлын бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн зөвлөлийн дүрмийг батлуулах зорилгоор тушаалын төсөл боловсрууллаа.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ